



112

МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2013 оны 05 сарын 02 өдөр

Дугаар 157

Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай

Эрүүл мэндийн удирдлагын мэдээллийн тогтолцоог 2011-2015 онд хөгжүүлэх стратегийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 3.2 дах заалтыг үндэслэн **ТУШААХ** нь:

1. Эрүүл мэндийн удирдлагын мэдээллийн тогтолцооны хүний нөөцийг 2013-2016 онд хөгжүүлэх төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг жил бүрийн салбарын төсөвт тусгах, олон улсын байгууллагуудын санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх талаар холбогдох арга хэмжээг авч, хэрэгжилтийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоодын аудитын газрын дарга (С.Төгсдэлгэр)-т үүрэг болгосугай.

САЙД



Н.УДВАЛ


002061

**ЭРҮҮЛ МЭНДИЙН УДИРДЛАГЫН МЭДЭЭЛЛИЙН ТОГТОЛЦООНЫ ХҮНИЙ НӨӨЦИЙГ
2013-2016 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ДУНД ХУГАЦААНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Эрүүл мэндийн сайдын
2013 оны 05 сарын 08 өдрийн /57/ тоот
тушаалын хавсралт

Зорилт 1. Эрүүл мэндийн удирдлагын мэдээллийн салбарт ажиллаж байгаа хүний нөөцийг хөгжүүлэх, чадавхийг дээшлүүлэхэд эрх зүйн орчинт боловсронгуй болгох	Үйл ажиллагаа				Хэрэгжих хугацаа (он)				Хариуцах байгууллага	Хамтрагч байгууллага
	Үйл ажиллагаа				13	14	15	16		
1. Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгүүдэд статистик, мэдээллийн бие даасан тасаг, нэгж ажиллуулах эрх зүйн орчин бүрдүүлэх									ЭМЯ /ХШУДАГ/	ЭМХТ
2. Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн статистикч их эмчийн ажлын байрны үлгэрчилсэн загвар/ тодорхойлолт боловсруулах									ЭМЯ /ТЗУГ, ХШУДАГ/	ЭМХТ НЭМГ
3. Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэгт ажиллах статистикч бага эмчийн тоог амбулаторын тусламж үйлчилгээ, эмнэлэгт хэвтүүлэн эмчлүүлэгчийн тооноос хамааруулан стандарчлах									ЭМЯ	ЭМХТ
4. Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэгт ажиллах статистикч бага эмч нарыг кодлогчоор бэлтгэж, мэргэшүүлэх									ЭМХТ	ЭМЯ
5. Төрөлжсөн мэргэжлээр мэргэшүүлэх сургалтын индекс кодлогч гэсэн индексийг шинээр оруулж, батлуулах									ЭМЯ /ТЗУГ, ХШУДАГ/	ЭМХТ
6. Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн амбулатор, стационарт ажиллах статистик бага эмчийн ажлын байрны үлгэрчилсэн загвар/тодорхойлолт боловсруулах, батлуулах									ЭМЯ /ТЗУГ, ХШУДАГ/	ЭМШУИС ЭМХТ
7. ЭМУМТ-ны хүний нөөцийн мэдээний санг бий болгох, баяжуулах									ЭМХТ	ЭМЯ

Үйл ажиллагаа		Хэрэгжих хугацаа (он)				Хариуцах байгууллага	Хамтрагч байгууллага
		13	14	15	16		
8.	Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн түвшинд гаргах үзүүлэлтийн жагсаалт, тооцох аргачлалыг боловсруулах, батлуулах					ЭМЯ	ЭМХТ
9.	Өрх, сумын эрүүл мэндийн төвийн түвшинд гаргах үзүүлэлтийн жагсаалт, тооцох аргачлалыг боловсруулах, батлуулах					ЭМЯ	ЭМХТ



Зорилт-2.
Өвчний олон улсын ангиллын хэрэглээг сайжруулах

10.	Өвчний түүх бичих стандарт шинэчлэх					ЭМЯ ЭМХТ	Мэргэжлийн салбар зөвлөл
11.	ӨОУА-10 –ын 3 дугаар ботийг орчуулах, хэвлэх					ЭМЯ	Мэргэжлийн салбар зөвлөл - ЭМХТ
12.	"ӨОУА-10 –ын хэрэглээний бүсчилсэн сургалт зохион байгуулах					ЭМЯ	ЭМХТ
13.	Үйлдлийн олон улсын –9 ангилалыг нэвтрүүлэх					ЭМЯ	ЭМХТ
14.	Олон улсын хавдарын өвчний ангилал О-3 –ийг үндэсний түвшинд нэвтрүүлэх					ЭМЯ	ХСҮТ
15.	Хавдарын бүртгэлийн тогтолцоонд Cancer-5 програм хангамжийг үндэсний түвшинд нэвтрүүлэх					ХСҮТ	ЭМЯ
16.	Үндэсний түвшинд хавдарын 5-6 кодлогч бэлтгэх					ХСҮТ	ЭМЯ
17.	ӨОУА-10 кодлогчтын олон улсын сургалтанд 3 хүнийг хамруулах, үндэсний сургагч багш бэлтгэх /Австрали улс/					ЭМЯ	-

Зорилт 3.
Мэдээний чанарын хяналт хийх тогтолцоо бүрдүүлэх

18.	Мэдээний чанарын хяналт хийх журам боловсруулах					ЭМХТ	
19.	Мэдээний чанарын аудит хийх чиглэлээр сургалт зохион байгуулах					ЭМХТ	Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, аймаг,
20.	Мэдээний чанарын хяналт хийх удирдамж болгосруулах						

Үйл ажиллагаа		Хэрэгжих хугацаа (он)				Хариуцах байгууллага	Хамтрагч байгууллага
		13	14	15	16		
21.	Мэдээний чанарын хяналтыг үндэсний түвшинд жил тутам хийж хэвших						дүүргийн нэгдсэн эмнэлэг
Зорилт 4.							
Төгсөлтийн дараах сургалтын чанар, агуулгыг сайжруулж, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэгт ажиллах статистику их, бага эмчийн хангамжийг стандартын түвшинд хүргэх							
22.	Статистикч их, бага эмчийн мэргэжил олгох, дээшлүүлэх сургалтын хөтөлбөр шинэчлэн боловсруулах					ЭМХТ	ЭМШУИС
23.	Статистикч их, бага эмчийн зэргийн шалгалтын гарын авлага боловсруулах, хэвлүүлэх					ЭМХТ	ЭМШУИС НЭМ-ийн салбар зөвлөл
24.	Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэгт ажиллах статистику их, бага эмчийг төрийн сангийн санхүүжилтээр сургах					ЭМХТ	Аймаг, нийслэлийн ЭМГ
25.	Гадаад танилцах аялалд эрүүл мэндийн статистик, мэдээллийн технологийн чиглэлээр жил бүр 2-3 хүнийг хамруулах					ЭМЯ	-
Зорилт 5.							
Цахим эмнэлгийг үе шаттайгаар хэрэгжүүлэх							
26.	Цахим эмнэлгийн стандарт програм хангамжийг бүх түвшинд үе шаттайгаар нэвтрүүлэх					ЭМЯ	ЭМХТ Сонгогдсон эрүүл мэндийн байгууллага
27.	Мэдээллийн технологийн мэргэжилтнүүдийг програм хангамж, сүлжээ, график дизайнд, өгөгдлийн сан, телемедицины чиглэлээр тасралтгүй сургалтанд хамруулах					ЭМЯ	ЭМХТ
28.	Үндэсний мэдээний тайлбар толийг боловсруулах					ЭМЯ	ЭМХТ
29.	Статистикч их эмч, мэдээллийн технологийн мэргэжилтнүүдийн зөөврийн компьютераар хангах					ЭМЯ	ЭМ ХТ
30.	Эрүүл мэндийн мэдээллийн төв байгуула ТЭЗҮ-ийг боловсруулах					ЭМЯ	ЭМХТ

